

# КАДАСТРЫН ЗУРАГЛАЛ БА ГАЗРЫН КАДАСТРЫН ТУХАЙ

1999 оны 12 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь бүх төрлийн кадастрын зураглал үйлдэх, газрын кадастр эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### 2 дугаар зүйл.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль тогтоомж

2.1.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Иргэний хууль, Газрын тухай хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3.Монгол Улсын иргэн, хуулийн этгээд гадаад улсын нутаг дэвсгэрт байгаа өөрийн өмчлөлийн газраа энэ хуульд заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

### 3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“кадастр” гэж газар болон бусад үл хөдлөх эд хөрөнгийн байршил, хил зааг, талбай, эзлэхүүн, тоо хэмжээ, төлөв байдлыг тогтоох, чанарын болон эдийн засгийн үнэлгээ хийх, төлбөр ногдуулах үндэслэлийг бий болгох, тэдгээрийн эзэмшил, ашиглалт, өмчлөлийн эрхийг баталгаажуулах цогц үйл ажиллагааг;

3.1.2.“кадастрын зураглал” гэж геодезийн хэмжилт, тодруулалт, боловсруулалтын үр дүнгээр бүх төрлийн кадастрын зураг үйлдэх үйл ажиллагааг;

3.1.3.“эдлэн газар” гэж Газрын тухай хуулийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд эзэмшүүлэх, ашиглуулах зорилгоор олгосон газрыг;

3.1.4.“нэгж талбар” (парсель) гэж хилээр хязгаарлагдсан, ашиглалтын зориулалт адил, эзэмшигч, ашиглагч, өмчлөгч нь нэг, оноосон дугаартай, кадастрт тусгавал зохих эдлэн газар, объект буюу түүний хэсгийг;

3.1.5.“эргэлтийн цэг” гэж нэгж талбарыг хязгаарласан хилийн шугамын нугаралтыг газар дээр нь болон кадастрын зураг дээр тодорхойлсон цэгийг;

3.1.6.“тодруулалт” гэж газрын зурагт үзүүлбэл зохих байгалийн болон хүний үйл ажиллагааны үр дүнд бий болсон объектыг агаарын ба хиймэл дагуулын дүрс, зураглалын бусад мэдээлэл дээр таньж тодорхойлох, кадастрын зурагт илэрхийлэгдэх өгөгдлүүдийг тогтоох геодези, зураг зүйн үйл ажиллагааг;

3.1.7.“кадастрын зураглалын мэдээллийн сан” гэж бүх төрлийн кадастрын зураг, орон зайн өгөгдлүүдийг цэгцлэн иж бүрдэл болгосон мэдээллүүд, тэдгээрийг боловсруулах, удирдах боломж бүхий техник хэрэгсэл ба программ хангамж бүхий мэдээллийн санг;

3.1.8.“газрын кадастр” гэж газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл, газрын

улсын бүртгэл эрхлэх үйл ажиллагааг;

3.1.9."газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл" гэж газрын нэгдмэл сангийн тооллого, газрын чанарын болон эдийн засгийн үнэлгээний үр дүнг тусгасан мэдээллийн цогц үйл ажиллагааг;

3.1.10."газрын нэгдмэл сангийн тооллого" гэж газрын нэгдмэл сангийн үндсэн, дэлгэрэнгүй ангиллын газрын байршил, хил зааг, тоо, хэмжээг тодорхойлох цогц үйл ажиллагааг;

3.1.11."газрын чанарын үнэлгээ" гэж газрыг түүний төлөв байдал, чанарыг илэрхийлэх үзүүлэлтээр харьцуулан үнэлэх үйл ажиллагааг;

3.1.12."газрын эдийн засгийн үнэлгээ" гэж газрыг түүний чадавх, эдийн засгийн үр өгөөжийг илэрхийлэх үзүүлэлтээр харьцуулан үнэлэх үйл ажиллагааг;

3.1.13."газрын кадастрын судалгаа" гэж газрын кадастрыг эрхлэхэд шаардлагатай мэдээллийг шалган нотлох, бүрдүүлэх, судлах, үнэлэх зорилго бүхий үйл ажиллагааг;

3.1.14."газрын улсын бүртгэл" гэж тодорхой хил заагаар бусад газраас тусгаарлагдсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эдлэн газрыг эзэмших, ашиглах эрх, түүний шилжилтийг бүртгэж, баталгаажуулах үйл ажиллагааг;

3.1.15."газрын мэдээллийн сан" гэж газрын нэгдмэл сангийн мэдээлэл, өгөгдөлд боловсруулалт хийх бололцоотой техник, технологид үндэслэсэн төр, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хэрэгцээг хангахуйц системчлэгдсэн өгөгдлүүдийн цогцыг.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **КАДАСТРЫН ЗУРАГЛАЛЫН ХАРИЛЦАА**

#### **4 дүгээр зүйл.Кадастрын зураглалын ангилал**

4.1.Кадастрын зураглалыг үл хөдлөх эд хөрөнгийн төрлөөс нь хамааруулан газрын, хот байгуулалтын, инженерийн шугаман байгууламжийн, геологи, уул уурхайн, бусад гэж ангилна.

4.2.Газрын кадастрын зураглалыг газрын үндсэн зориулалт, хэрэгцээг харгалзан газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллаар ялгаж газар, хөрс, ус, ургамлын байр зүйн агуулгатайгаар үйлдэнэ.

4.3.Хот байгуулалтын кадастрын зураглалыг газрын гадарга дээр болон доор орших зам талбайн, ногоон байгууламжийн, барилга байгууламжийн, газар дээрх болон доорх инженерийн шугам сүлжээний, гэр хорооллын, инженер геологийн, ус, ус сувгийн гэсэн дэд ангиллаар ялгаж хот байгуулалтын байр зүйн агуулгатайгаар үйлдэнэ.

4.4.Инженерийн шугаман байгууламжийн кадастрын зураглалыг газрын гадарга дээр болон доор байгуулсан авто, төмөр замын, иргэний нислэгийн аэродромын, түлш, эрчим хүчний, харилцаа холбооны, усан хангамжийн байгууламж, услалтын системийн гэсэн дэд ангиллаар ялгаж дэд бүтцийн байр зүйн агуулгатайгаар үйлдэнэ.

4.5.Геологи, уул уурхайн кадастрын зураглалыг геологи, эрэл хайгуулын, уурхайн, нөөцөд авсан талбайн гэсэн дэд ангиллаар ялгаж геологи, уул уурхайн байр зүйн агуулгатайгаар үйлдэнэ.

4.6.Бусад ангиллын кадастрын зураглалыг холбогдох үзүүлэлтээс нь хамааруулан тус тусын дэд ангиллаар ялгаж тухайн ангилалд хамаарах байр зүйн агуулгатайгаар үйлдэнэ.

4.7.Кадастрын зураглалд орох өөрчлөлтийг тухай бүр нь хийж кадастрын зураглалын мэдээллийн санд жилд нэг удаа оруулна.

## **5 дугаар зүйл.Кадастрын зураглалын солбицлын тогтолцоо, масштаб, нарийвчлал**

5.1.Бүх ангиллын кадастрын зураглалыг Геодези, зураг зүйн тухай хуульд заасан стандартын дагуу улсын геодезийн сүлжээнд холбож гүйцэтгэнэ.

5.2.Бүх ангиллын кадастрын зургийг мөрдөж байгаа зураг зүйн тусгаг, байр зүйн хавтгайн тогтолцоонд өргөрөг, уртрагийн өнцгийн болон далайн түвшнээс дээших харьцангуй өндрийн тоон хэмжээсээр тус тус илэрхийлнэ.

5.3.Кадастрын зургийг тухайн кадастрын үндсэн болон дэд ангиллаас нь хамааруулан дараахь масштабаар тус тус үйлдэнэ:

5.3.1.энэ хуулийн 4.1.2; 4.1.3 -т заасан төрлийн кадастрын зургийг 1:2000-аас багагүй масштабаар;

5.3.2.жимс жимсгэнэ, ногооны талбайн кадастрын зургийг 1:2000-аас, тариалангийн талбайд 1:25000-аас, хадлангийн талбайд 1:50000-аас, бэлчээр, ой, усан сан, геологи, уул уурхайн талбайд 1:100000-аас тус тус багагүй масштабаар.

5.4.Кадастрын зургийн нарийвчлал нь тухайн масштабын 0,1 мм-т ногдох хэмжээнээс ихгүй байна.

## **6 дугаар зүйл.Кадастрын зураглалын мэдээллийн сан**

6.1.Кадастрын зураглалын мэдээллийн сан нь геодези, зураг зүйн улсын нэгдсэн сангийн дэд сан байна.

6.2.Кадастрын зураглалын мэдээллийн санд дор дурдсан ажлын үр дүн, зураг мэдээлэл, бичиг баримт орно:

6.2.1.кадастрын зураглалын техникийн тайлан, гүйцэтгэсэн аж ахуйн нэгж, байгууллагын оноосон нэр, улсын бүртгэлийн дугаар, шуудангийн хаяг;

6.2.2.зураглалын үндэслэлийн болон хээрийн холболтын цэгүүдийн тэгшитгэн боловсруулсан солбицол, өндрийн жагсаалт, нарийвчлалын өгөгдөл, геодезийн ба зураглалын сүлжээний байрлалын бүдүүвч;

6.2.3.эдлэн газар болон нэгж талбарын ялгах дугаар, хилийн шугамын эргэлтийн цэгийн солбицол, өндрийн жагсаалт, тодорхойлолтын нарийвчлалын үзүүлэлт;

6.2.4.байр зүйн болон сэдэвчилсэн тодруулалтын зураг, тодорхойлолтын баримт бичиг;

6.2.5.зураглалын явцад шинээр байгуулсан үндэслэлийн цэгүүдийн төв, тэмдэгтийн бүдүүвч, тодорхойлолт;

6.2.6.ортофото зураг, кадастрын тоон зураг болон бусад шаардлагатай баримт бичиг.

## **7 дугаар зүйл.Кадастрын зураглал эрхлэх байгууллага, түүний чиг үүрэг**

7.1.Кадастрын зураглалыг мэргэжлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэн холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэнэ.

*/Энэ хэсэгт 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хууль, 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

7.2.Кадастрын зураглал гүйцэтгэсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэн хууль тогтоомжийн дагуу ажлаа нэг бүрчлэн шалгуулж, шалгалтын актаар бүх зураг, мэдээллийн эх хувийг кадастрын зураглалын мэдээллийн санд хүлээлгэн өгнө.

7.3.Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч, эзэмшигч, ашиглагч төрийн болон

бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь кадастрын зураг хийлгэх захиалгаа геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх бөгөөд захиалгадаа дор дурдсан баримт бичгийг хавсаргана:

7.3.1.захиалагч аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, оршин байгаа хаяг, иргэний хувьд регистрийн дугаар, оршин суугаа хаяг;  
*/Энэ заалтад 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

7.3.2.үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн баримт бичиг, талбайн байрлал, хэмжээ, хилийн шугам, түүний эргэлтийн цэгүүдийн тухай тодорхойлолт.

7.4.Үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөгч, эзэмшигч, ашиглагч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь дараахь үүрэгтэй байна:

7.4.1.кадастрын зураглал гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг өөрийн эдлэн газартаа саадгүй нэвтрүүлж, ажиллах, мэдээлэл авах боломжоор хангах;

*/Энэ заалтад 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

7.4.2.өөрийн эдлэн газрын хилийн эргэлтийн цэгүүдийг газар дээр нь тэмдэглэсэн тэмдэгтийг хамгаалалтандаа авч, бүрэн бүтэн байдлыг хариуцах.

7.5.Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь кадастрын зураглалын талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.5.1.бүх ангиллын кадастрын зураглалын стандарт, технологийн аргачлал, дүрэм, журмыг батлуулан мөрдүүлэх;

*/Энэ заалтыг 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

7.5.2.геодези, зураг зүйн ажил эрхлэх эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд кадастрын зураглал хийх тусгай зөвшөөрөл олгох;

*/Энэ заалтыг 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

7.5.3.захиалагч, гүйцэтгэгчийг холбогдох мэдээллээр хангах;

7.5.4.кадастрын зураглал хийх технологийн бүх дамжлага, үе шатанд мэргэжлийн хяналт тавих, шаардлагатай бол магадлан хэмжилт хийх;

7.5.5.бүх ангиллын кадастрын зураглалын материалыг хүлээн авч, мэдээллийн сан бүрдүүлэх, кадастрын зураг, дагалдах мэдээллээр бүртгэлийн болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд үйлчлэх;

7.5.6.кадастрын зураглалд ашиглагдаж байгаа зураг, мэдээллийн нууцыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хамгаалах;

7.5.7.Монгол Улсын улсын хилийн бүс болон батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, цэрэг стратегийн зориулалтын газарт бүх ангиллын кадастрын зураглал үйлдэх, ашиглах зөвшөөрлийг улсын хил хамгаалах байгууллагатай хамтран олгох;

7.5.8.үл хөдлөх эд хөрөнгийн байршлын талаархи маргааныг мэдээллийн санд байгаа өгөгдлөөр шалгах, мэргэжлийн дүгнэлт гаргах;

7.5.9.энэ хуулийн 7.3-т заасан захиалга, түүнд хавсаргасан баримт бичгийг хүлээн авч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах хугацааг товлож тэмдэглэн өгөх;

7.5.10.кадастрын зураг хийлгэх захиалгыг хүлээн авч уг ажлыг эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд зарлан мэдээлэх;

7.5.11.гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журам, комиссын бүрэлдэхүүнийг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар

батлуулан хэрэгжүүлэх;

*/Энэ заалтад 2003 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

7.5.12.захиалагч болон гүйцэтгэгчийн эрх бүхий төлөөлөгчтэй гурван талын гэрээ байгуулах;

7.5.13.газрын кадастрын зураглалын ажлын үр дүнг газрын мэдээллийн улсын санд үнэ төлбөргүй шилжүүлэн өгөх.

## **8 дугаар зүйл.Кадастрын зураглалын санхүүжилт**

8.1.Засгийн газраас нэгдсэн журмаар гүйцэтгэж байгаа кадастрын зураглалын ажлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

8.2.Нутгийн захиргааны байгууллага шаардлагатай гэж үзвэл кадастрын зураглалыг захиалан өөрийн төсвөөсөө санхүүжүүлж болно.

8.3.Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн кадастрын зураглал хийгдээгүй талбайд аж ахуйн нэгж, байгууллага, иргэн өөрийн хөрөнгөөр захиалж кадастрын зураглал хийлгэнэ.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ГАЗРЫН КАДАСТРЫН ХАРИЛЦАА**

### **9 дүгээр зүйл.Газрын кадастр**

9.1.Газрын кадастр дараахь үйл ажиллагаанаас бүрдэнэ:

9.1.1.газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл;

9.1.2.газрын улсын бүртгэл.

9.2.Газрын нэгдмэл сангийн тоо бүртгэлд дараахь үйл ажиллагаа хамаарна:

9.2.1.газрын кадастрын зураглал;

9.2.2.газрын кадастрын судалгаа;

9.2.3.газрын чанарын үнэлгээ;

9.2.4.газрын эдийн засгийн үнэлгээ.

9.3.Газрын улсын бүртгэлд дараахь үйл ажиллагаа хамаарна:

9.3.1.газрын кадастрын зураглал;

9.3.2.газар эзэмших, ашиглах эрхийн бүртгэл.

9.4.Газрын кадастрын үр дүн газрын мэдээллийн санг бүрдүүлнэ.

### **9<sup>1</sup> дүгээр зүйл.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

9<sup>1</sup>.1.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага кадастрын үйл ажиллагаатай холбоотой дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9<sup>1</sup>.1.1.бүх ангиллын кадастрын зураглалын стандарт, технологийн аргачлал, дүрэм, журмыг батлуулан мөрдүүлэх;

~~9<sup>1</sup>.1.2.геодези, зураг зүйн ажил эрхлэх эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд кадастрын зураглал хийх тусгай зөвшөөрөл олгох;~~

~~*/Энэ заалтыг 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болгоход төөцсөн/*~~

9<sup>1</sup>.1.3.газрын кадастр хийх нутаг дэвсгэрийн ээлж дарааллыг тогтоох, газрын кадастрын судалгааг гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд нь хяналт тавих.

*/Энэ заалтад 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

*/Дээрх 91 дүгээр зүйлийг 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн/*

## **10 дугаар зүйл. Газрын кадастр эрхлэх байгууллага, түүний чиг үүрэг**

10.1. Газрын кадастрыг суманд газрын даамал, аймаг, нийслэл, дүүрэгт газрын алба, улсын хэмжээнд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэнэ.

*/Энэ хэсгийг 2003 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

10.2. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хрэгжүүлнэ:

*/Энэ хэсэгт 2003 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

10.2.1. газрын кадастрыг удирдах, зохион байгуулах;

10.2.2. газрын мэдээллийн улсын санг бүрдүүлэх, хөтлөх, нийтэд үйлчлэх үйл ажиллагааг зохицуулах;

~~10.2.3. газрын кадастр хийх нутаг дэвсгэрийн ээлж дарааллыг тогтооход, газрын кадастрын судалгааг гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагад, зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих;~~

*/Энэ заалтыг 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

10.2.4. газрын кадастрын зураг захиалах, хүлээн авах;

10.2.5. газрын кадастрын талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор холбогдох журам, заавар, аргачлалыг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

10.2.6. аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эдлэн газрыг бүртгэлд хамруулан, лавлагааны нэгдсэн зургийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр хөтлөх;

10.2.7. газрын нэгдмэл сангийн үндсэн, дэлгэрэнгүй ангилалд орж байгаа өөрчлөлт, хөдөлгөөний талаархи тайланг Засгийн газарт жил бүр гаргаж, энэ талаархи мэдээллээр нийтэд үйлчлэх;

10.2.8. хуульд заасан бусад чиг үүрэг.

## **11 дүгээр зүйл. Газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл**

11.1. Газрыг эзэмшил, эсхүл ашиглалтад олгосноос үл хамааруулан газрын тоо бүртгэлийг нэгдмэл сангийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бүрээр хөтлөж, газрын мэдээллийн улсын санд оруулна.

11.2. Газрын тоо бүртгэлд газрын үндсэн ангиллын газрын хэмжээ, түүний төлөв байдал, чанар, өөрчлөлтийг тусгана.

11.3. Газрын тоо бүртгэлд хамаарах үзүүлэлт, түүнийг хөтлөх журмыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно.

*/Энэ хэсэгт 2003 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

## **12 дугаар зүйл. Газрын кадастрын зураглал**

12.1. Газрын кадастрын зураглалтай холбогдсон харилцааг энэ хуулийн хоёрдугаар бүлэгт заасны дагуу зохицуулна.

## **13 дугаар зүйл. Газрын кадастрын судалгаа**

13.1. Газрын кадастрын судалгааг мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж гүйцэтгэнэ.

*/Энэ хэсэгт 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

13.2. Газрын кадастрын судалгаа дараах үйл ажиллагаанаас бүрдэнэ:

13.2.1. газрын нэгдмэл сангийн тооллого явуулах;

13.2.2.газрын төлөв байдал, чанар, чадавх, эдийн засгийн үр өгөөж, өөрчлөлтийг илэрхийлж байгаа үзүүлэлтийг бодит байдлаар тогтоож, чанарын болон эдийн засгийн үнэлгээ хийх;

13.2.3.эдлэн газрыг үндсэн зориулалтаар нь эзэмшиж, ашиглаж байгаа эсэхийг шалган нотлох;

13.2.4.эдлэн газар, нэгж талбаруудын газрын ерөнхий болон оноосон хил, заагийг газрын улсын бүртгэлийн холбогдох бичиг баримтыг үндэслэн шалган нотлох.

13.3.Энэ хуулийн 13.2.1-д заасан үйл ажиллагааг газрын нэгдмэл сангийн ангилал өөрчлөгдөх бүрд болон 5 жилд нэг удаа; нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийн тооллогыг тухайн шатны нутгийн захиргааны байгууллагын болон газар эзэмшигч, ашиглагчийн захиалгаар хугацаа харгалзахгүйгээр хийнэ.

13.4.Газрын нэгдмэл сангийн тооллогыг газрын үндсэн, дэлгэрэнгүй ангиллаар зураглал, бичлэг үйлдэж, түүний байршил, талбайн хэмжээг тодорхойлох замаар явуулна.

13.5.Газрын нэгдмэл сангийн тооллого явуулсан мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж тооллогын дүнгийн тухай мэдээ, баримт бичгийг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн байгууллагаар хянуулж баталгаажуулна.

13.6.Тооллогын баримт бичгийг 3 хувь үйлдэж, аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн байгууллага болон захиалагчид тус бүр нэг хувийг хүлээлгэн өгнө.

13.7.Газрын нэгдмэл сангийн тооллого нь газрын нэгдмэл сангийн тоо бүртгэлийг бүрдүүлэх анхдагч мэдээлэл болно.

#### **14 дүгээр зүйл.Газрын чанарын үнэлгээ**

14.1.Газрын чанарын үнэлгээг газрын чадавхийг тогтоосны үндсэн дээр газрын талаар төрөөс баримтлах бодлого, газар зохион байгуулалт, газрын эдийн засгийн үнэлгээ хийх үндэслэлийг бүрдүүлэх, газар ашиглалтын зориулалтыг тодорхойлох зорилгоор хийнэ.

14.2.Газрын чанарын үнэлгээг газрын нэгдмэл сангийн тооллогын үр дүн, хөрс, ус, ургамал, газрын төлөв байдал, чанар, чадавхийн судалгааг үндэслэн хийнэ.

14.3.Газрын чанарын үнэлгээ хийх аргачлал, үзүүлэлтийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

*/Энэ хэсэгт 2003 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

#### **15 дугаар зүйл.Газрын эдийн засгийн үнэлгээ**

15.1.Газрын эдийн засгийн үнэлгээг газрын суурь үнэ, төлбөрийн хэмжээг тогтоох, газрын өгөөжийг тодорхойлох зорилгоор хийнэ.

15.2.Газрын эдийн засгийн үнэлгээ хийх аргачлал, үзүүлэлтийг Засгийн газар батална.

*/Энэ хэсэгт 2003 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

#### **16 дугаар зүйл.Газрын улсын бүртгэл**

*16.1.Энэ хэсгийг 2003-оны 6-дугаар сарын 12-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон*

16.2.Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэл хөтлөхтэй холбоотой харилцааг Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн

бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулиар зохицуулах бөгөөд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ талаарх мэдээллийг газрын мэдээллийн санд гаргаж өгнө.

*/Энэ хэсгийг 2003 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

*/Энэ хэсэгт 2006 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

16.3. Аж ахуйн, нэгж, байгууллага, иргэн хэд хэдэн эдлэн газартай бол эдлэн газар бүрийг газрын улсын бүртгэлд бүртгэнэ.

16.4. Эдлэн газар нь хэд хэдэн нэгж талбартай бол түүний гэрчилгээнд нэгж талбар бүрийг тэмдэглэнэ.

16.5. Газрын улсын бүртгэлийн мэдээлэл нь хуулиар хориглосноос бусад нөхцөлд нээлттэй байна.

16.6. Газрын улсын бүртгэлийн мэдээллийн үндсэн нэгж нь эдлэн газар байна.

16.7. Эдлэн газар болон нэгж талбар бүр дугаартай байна.

16.8. Газрын улсын бүртгэлд бүртгэгдсэн эдлэн газар бүр түүнийг бусад газраас заагласан ерөнхий хилтэй байна.

16.9. Хэсгээр дундаа эзэмшиж, ашиглаж байгаа эдлэн газрын эзэмшигч, ашиглагч тус бүрт хамаарах хэсгүүд оноосон хилтэй байна.

16.10. Нэгж талбар заагтай байна.

16.11. Газрын кадастрын зурагт ерөнхий болон оноосон хил, заагийг харуулна.

16.12. Ерөнхий болон оноосон хил, зааг, тэдгээрийн эргэлтийн цэгийн байрлалыг байгалийн байнгын биет, хүний бүтээсэн байгууламж, тэмдэглээс, геодезийн байнгын цэг, тэмдэгтүүдийг ашиглан газар дээр нь тэмдэглэж газрын кадастрын зурагт буулгана.

16.13. Газар дээр нь тэмдэглэж газрын кадастрын зурагт буулгасан ерөнхий хил нь газар олгоходоо тогтоосон хилийн цэстэй, оноосон хил нь газрыг хэсгээр дундаа эзэмшигчдийн бичгээр гаргасан зөвшөөрөлд заасан, эсхүл газар олгоход эрх бүхий этгээдээс тогтоосон хилтэй тохирч байна.

16.14. Эдлэн газрын ерөнхий болон оноосон хилийн эргэлтийн цэгийн байрлалыг шаардлагатай үед тэмдэглэн бэхжүүлэх тэмдэгтийн загвар, хэмжээ, үйлдэх, суулгах журмыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно.

*/Энэ хэсэгт 2003 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

~~16.15. Энэ хэсгийг 2003 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон~~

## **17 дугаар зүйл. Газрын мэдээллийн сан**

17.1. Газрын мэдээллийн сан нь сум, дүүргийн, аймаг, нийслэлийн болон улсын сангаас бүрдэх бөгөөд дор дурдсан үндсэн хэсэгтэй байна:

17.1.1. газрын кадастрын зураг;

17.1.2. газрын кадастрын судалгааны материал;

17.1.3. газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл;

17.1.4. газрын чанарын үнэлгээний дүн;

17.1.5. газрын эдийн засгийн үнэлгээний дүн;

17.1.6. газрын улсын бүртгэл.

17.2. Газрын мэдээллийн сангийн үйл ажиллагаа, мэдээлэл солилцооны журмыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно.



*/Энэ хэсэгт 2003 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

### **БУСАД ЗҮЙЛ**

#### **18 дугаар зүйл.Кадастрын зураглалын хяналт, магадлан хэмжилт**

18.1.Кадастрын зураглалын улсын хяналтыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.

18.2.Магадлан хэмжилтийг өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн хүсэлт, эрх бүхий байгууллагын шийдвэрээр гүйцэтгэнэ.

~~18.3.Кадастрын зураглал эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэн Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль тогтоомжийг давтан зөрчсөн тохиолдолд олгосон зөвшөөрлийг зөвшөөрөл олгосон этгээд 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар хүчингүй болгоно.~~

*/Энэ хэсгийг 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

#### **19 дүгээр зүйл.Кадастрын зураглалын талаар хориглох үйл ажиллагаа**

19.1.Байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

19.1.1.эзэмшиж, ашиглаж байгаа газартаа геодезийн цэг, тэмдэгт болон эдлэн газрын хил заагийн тэмдэглээсийг гэмтээх, устгах, зохих зөвшөөрөлгүй нүүлгэн шилжүүлэх;

19.1.2.эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр кадастрын зураглалын мэдээллийг засварлах, бусдад дамжуулах.

#### **20 дугаар зүйл.Маргааныг хянан шийдвэрлэх**

20.1.Кадастрын зураглалтай холбогдсон маргааныг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шийдвэрлэх ба уг шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргана.

20.2.Газрын кадастртай холбогдсон маргааныг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шийдвэрлэх ба уг шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргана.

*21 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага*

21.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

21.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

*/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

# АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ

2001 оны 2 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, тодорхой нөхцөл, нарийн мэргэжил шаардах аж ахуйн зарим үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

### 2 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль тогтоомж

2.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль тогтоомж нь Иргэний хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3. Газар, байгалийн баялгийг ашиглахтай холбогдож олгох зөвшөөрлийг Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Байгалийн ургамлын тухай, Амьтны тухай, Ойн тухай, Усны тухай, Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай, Ашигт малтмалын тухай, Цөмийн энергийн тухай, Хувиргасан амьд организмын тухай хуулиар тус тус зохицуулна.

*/Энэ хэсэгт 2002 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

*/Энэ хэсэгт 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

*/Энэ хэсэгт 2007 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

*/Энэ хэсэгт 2009 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

*/Энэ хэсэгт 2012 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

### 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл" /цаашид "тусгай зөвшөөрөл" гэх/-гэж тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг иргэн, ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдэд эрх бүхий байгууллагаас олгосон албан ёсны баримт бичгийг;

3.1.2. "тусгай зөвшөөрөл эзэмшигч" гэж тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэхээр эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан этгээдийг.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ОЛГОХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

### 4 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийн агуулга

4.1. Тусгай зөвшөөрөлд дор дурдсан зүйлийг тусгана:

- 4.1.1. тусгай зөвшөөрлийг олгосон байгууллагын нэр;
- 4.1.2. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг;
- 4.1.3. эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрөл;
- 4.1.4. тусгай зөвшөөрлийн хугацаа;
- 4.1.5. тусгай зөвшөөрлөөр эрхлэх аж ахуйн үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлага;
- 4.1.6. тусгай зөвшөөрлийн дугаар, олгосон он, сар, өдөр;
- 4.1.7. тусгай зөвшөөрөл олгосон байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга /тэмдэг/.

## **5 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээ**

5.1. Тусгай зөвшөөрөл шаардах аж ахуйн үйл ажиллагааг хэрэв тусгайлан заасан бол тухайн нутаг дэвсгэрт явуулна.

5.2. Тусгай зөвшөөрөл шаардахаас бусад төрлийн аж ахуйн үйл ажиллагааг хууль тогтоомж, стандарт шаардлагад нийцүүлэн, зөвхөн татварын байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр чөлөөтэй эрхэлж болно.

*/Энэ хэсэгт 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

5.3. Тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

5.4. Тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг эрхлэх эрх энэ хуульд заасны дагуу тусгай зөвшөөрлийг авсан өдрөөс үүснэ.

*/Энэ хэсгийг 2002 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн/*

## **6 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн хугацаа, түүнийг сунгах**

6.1. Хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрлийг 3 жилээс доошгүй хугацаагаар олгоно.

6.2. Тусгай зөвшөөрлийг хуульд өөрөөр заагаагүй бол анх олгосон хугацаанаас нь доошгүй хугацаагаар сунгаж болно.

6.3. Хэрэв хуульд өөрөөр заагаагүй, энэ хуулийн 13.1-д заасан нөхцөл байдал илрээгүй тохиолдолд зөвхөн зөвшөөрөл эзэмшигчийн өргөдлийг үндэслэн 3 хоногийн дотор тусгай зөвшөөрлийн хугацааг сунгана.

6.4. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахгүй.

## **7 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох журам**

7.1. Энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрлийг хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны холбогдох төв байгууллага олгоно.

7.2. Хуульд заасан бол хүнсний чиглэлийн үйл ажиллагааг зөвшөөрөл авсны үндсэн дээр эрхэлнэ.

*/Энэ хэсгийг 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

7.3. Тухайн төрлийн аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журмыг тус тусын хуулиар зохицуулна.

7.4. Эрх бүхий байгууллага шаардлагатай гэж үзвэл сонгон шалгаруулалтын үндсэн дээр тусгай зөвшөөрөл олгож болно.

## **8 дугаар зүйл. Хориглох аж ахуйн үйл ажиллагаа**

8.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт дараахь төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

8.1.1. хар тамхи, хуульд өөрөөр заагаагүй бол мансууруулах бодис

үйлдвэрлэх, импортлох, худалдах;

*/Энэ заалтад 2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

8.1.2.садар самуун явдлыг зохион байгуулах, түүнийг аливаа хэлбэрээр сурталчлах, дэмжих;

8.1.3.казиногийн үйл ажиллагаа эрхлэх;

8.1.4.олон шатлалт маркетинг буюу пирамид тогтолцооны замаар хууран мэхэлж ашиг хонжоо олох үйл ажиллагаа.

8.2.Энэ хуулийн 8.1.3 дахь заалт нь чөлөөт бүсийн тухай хууль тогтоомжид хамаарахгүй

*/Энэ хэсгийг 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар нэмсэн/*

### **9 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл олгоход баримтлах зарчим, шаардлага**

9.1.Эрх бүхий байгууллага тусгай зөвшөөрөл олгохдоо дараахь зарчмыг баримтална:

9.1.1.улс орныг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах, нийтийн эрх ашиг, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

9.1.2.аж ахуй эрхлэх таатай орчныг бүрдүүлэх;

9.1.3.ил тод, шуурхай байх;

9.1.4.зөвхөн хуульд заасан тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох.

### **10 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох байгууллагын эрх**

10.1.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь дараахь эрхтэй:

10.1.1.хуульд заасан нөхцөл, журмын дагуу тусгай зөвшөөрөл олгох;

10.1.2.тусгай зөвшөөрлийг бүртгэх;

10.1.3.тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаад хяналт тавих;

10.1.4.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх;

10.1.5.тусгай зөвшөөрлийг сунгах, хүчингүй болгох.

### **11 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг**

11.1.Тусгай зөвшөөрөл хүсэгч дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:

11.1.1.тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл /эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, хугацааг тодорхой дурьдах/;

11.1.2.тусгай зөвшөөрөл хүсэгч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ;

11.1.3.тусгай зөвшөөрөл хүсэгч нь иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;

*/Энэ заалтыг 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

11.1.4.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

11.1.5.тухайн үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогоос шалтгаалан хуульд заасан бусад баримт бичиг;

11.1.6.үйл ажиллагаа явуулах барилга байгууламжийн гаднах орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулж, энэ талаар цагдаагийн байгууллагын саналыг авсан байх;

*/Энэ заалтыг 2017 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/*

11.1.7.энэ хуулийн 15.5.7; 15.5.8; 15.6.1-15.6.3; 15.6.5; 15.8.3; 15.8.8; 15.8.18;

15.8.20; 15.10.4-15.10.6; 15.10.14; 15.11.1; 15.11.2; 15.12.1-15.12.6-д заасан аж ахуйн үйл ажиллагааг эрхлэхэд аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг авсан байна.

*/Энэ заалтад 2005 оны 7 дугаар 1-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан, энэ заалтын дугаарыг 2017 оны 2 дугаар 09-ний өдрийн хуулиар өөрчилсөн/*

11.1.8.энэ хуулийн 15.11.4-т заасан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд улсын болон бүс, нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах тохиолдолд хяналтын төв албаны, орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах тохиолдолд аймаг, нийслэлийн хяналтын албаны дүгнэлт авсан байна.

*/Энэ заалтыг 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн./*

11.2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад баримт бичиг, төлбөр, хураамж шаардаж болохгүй.

11.3.Энэ хуулийн 15.10.5, 15.10.6-д заасан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход аймаг, нийслэлийн Засаг дарга саналаа 30 хоногийн дотор Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлээгүй бол зөвшөөрсөн гэж үзнэ.

*/Энэ хэсгийг 2006 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/*

11.4.Энэ хуулийн 11.1.6-д заасан дүрс бичлэгийн техник, хэрэгслийн стандартыг Стандартчиллын үндэсний зөвлөл батална.

*/Энэ хэсгийг 2017 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/*

## **12 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох**

12.1.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, холбогдох бусад баримт бичгийг хянан үзэж, тусгай зөвшөөрөл олгох эсэх тухай асуудлыг хуульд өөрөөр заагаагүй бол өргөдөл хүлээн авснаас хойш ажлын 21 хоногийн дотор шийдвэрлэнэ.

12.2.Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан бол татгалзсан үндэслэлийг зааж бичгээр хариу өгнө.

12.3.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь шаардлагатай бол өргөдөл гаргагчийн баримт бичгийг холбогдох байгууллагаар нягтлан шалгуулах, магадлан шинжилгээ хийлгэх эрхтэй.

12.4.Магадлан шинжилгээ хийлгэх тохиолдолд өргөдлийг шийдвэрлэх хугацааг 14 хоногоор сунгаж болно.

12.5.Энэ хуулийн 15.10.17-д заасан тусгай зөвшөөрлийг холбогдох мэргэжлийн холбооны гишүүн хуулийн этгээдэд олгоно.

*/Энэ хэсгийг 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн/*

## **13 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх**

13.1.Тусгай зөвшөөрлийн хугацаа, нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага түүнийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно.

13.2.Тусгай зөвшөөрлийг олгосон эрх бүхий байгууллага нь түдгэлзүүлсэн шийдвэрийн талаар тусгай зөвшөөрөл эзэмшигч болон харьяалах татварын албанд 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

13.3.Тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага нь тусгай зөвшөөрлийн үйлчлэлийг түдгэлзүүлсэн нөхцөл арилсан тохиолдолд уул зөвшөөрлийг сэргээнэ.

## **14 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох**

14.1.Тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага нь дараахь тохиолдолд

тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

14.1.1. тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

14.1.2. хуулийн этгээд татан буугдсан;

14.1.3. тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;

14.1.4. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

*/Энэ заалтад 2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

14.1.5. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй.

14.1.6. стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль тогтоомжийг зөрчсөн.

*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн, 2013 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

14.2. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай шийдвэрийн талаар тусгай зөвшөөрөл олгосон байгууллага нь шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигч болон харьяалах татварын албанд бичгээр мэдэгдэнэ.

## **15 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрөл**

15.1. Энэ зүйлд заасан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ.

15.2. Банкны үйл ажиллагааны чиглэлээр:

15.2.1. банк байгуулах, банкны үйл ажиллагаа эрхлэх.

*15.2.2. /Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

15.3. Банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр:

15.3.1. банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх;

15.3.2. арилжааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх;

15.3.3. даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх;

15.3.4. банкнаас бусад этгээд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх;

15.3.5. үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх;

*/Энэ заалтыг 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

15.3.6. хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах;

*/Энэ заалтыг 2010 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн/*

15.3.7. барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг хянагчийн үйл ажиллагаа эрхлэх;

*/Энэ заалтыг 2010 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн/*

15.3.8. хөрөнгөөр баталгаажсан үнэт цаастай холбоотойгоор хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх;

*/Энэ заалтыг 2010 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн/*

15.3.9. зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх.

*/Энэ заалтыг 2011 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмсэн/*

*/Энэ хэсгийг 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

15.4. Санхүү, эдийн засгийн чиглэлээр:

15.4.1. нийгмийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх;

*/Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

15.4.2.аудитын үйл ажиллагаа эрхлэх;

15.4.3.үнэт цаас үйлдвэрлэх;

15.4.4.эд мөнгөний хонжворт сугалаа гаргах;

~~15.4.5./Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~15.4.6./Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

15.4.7.гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх;

15.4.8.гаалийн баталгаат бүсэд үйл ажиллагаа эрхлэх;

*/Энэ заалтад 2008 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

15.4.9.хөрөнгийн үнэлгээ хийх;

*/Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

15.4.10.татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх.

*/Энэ заалтыг 2012 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн/*

15.5.Хууль зүйн чиглэлээр:

15.5.1.нотариатын үйл ажиллагаа эрхлэх;

15.5.2.галт зэвсэг, сум импортлох, нийтэд худалдах;

15.5.3.галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл үйлдвэрлэх;

15.5.4.галт зэвсгийн сум үйлдвэрлэх, дахин цэнэглэх;

15.5.5.галт зэвсгийн сум импортлох, нийтэд худалдах;

15.5.6.галт зэвсэг, сум ашиглан спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх;

15.5.7.хуулийн этгээд харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх;

15.5.8.төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх;

15.5.9.тамга, тэмдэг үйлдвэрлэх.

*/Энэ хэсэгт 2004 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

*/Энэ хэсгийг 2015 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

15.6.Байгаль орчны чиглэлээр:

15.6.1.озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүнийг импортлох, худалдах, ашиглах;

15.6.2.тэсэрч, дэлбэрэхээс бусад химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэх;

*/Энэ заалтад 2006 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

15.6.3.тэсэрч дэлбэрэхээс бусад химийн хорт болон аюултай бодис импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх, ашиглах, худалдах, устгах;

*/Энэ заалтад 2006 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн хууль, 2008 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн хуулиар тус тус өөрчлөлт, 2013 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

~~15.6.4./Энэ заалтыг 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

15.6.5.стандартаар хүлцэх хэмжээг нь тогтоогоогүй бохирдуулах бодис агаарт гаргах;

15.6.6.байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх;

15.6.7.байгаль орчинд онцгой хор хөнөөл учруулж болзошгүй нөлөө бүхий химийн хорт болон аюултай бодис импортлох, худалдах, үйлчилгээ эрхлэх.

*/Энэ заалтыг 2008 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн хуулиар нэмсэн/*  
15.7.Боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлээр:  
15.7.1.их сургууль, дээд сургууль, коллежийн үйл ажиллагаа эрхлэх;  
*/Энэ заалтыг 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хууль, 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөн найруулсан/*  
15.7.2.магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх;  
15.7.3.түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлсийг улсын хилээр нэвтрүүлэх;  
15.7.4.дээд боловсролын шинэ мэргэжлээр сургалт явуулах;  
*/Энэ заалтыг 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*  
15.7.5.мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаа эрхлэх;  
*/Энэ заалтыг 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмсэн, 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*  
15.7.6.мэргэжлийн боловсрол, сургалтын шинэ мэргэжлээр сургалт явуулах;  
*/Энэ заалтыг 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмсэн, 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*  
15.7.7.гадаад улсад боловсрол эзэмшүүлэх, сургалтад хамруулахад зуучлах үйлчилгээ;  
*/Энэ заалтыг 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/*  
15.7.8.олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль болон ерөнхий боловсролын лаборатори сургуулийг байгуулах;  
*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/*  
15.7.9.гадаадын хөрөнгө оруулалттай цэцэрлэг, сургууль байгуулах;  
*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/*  
15.7.10.соёлын өвийг сэргээн засварлах, палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх.  
*/Энэ заалтыг 2014 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар нэмсэн/*  
15.8.Түлш, эрчим хүчний чиглэлээр:  
~~15.8.1./Энэ заалтыг 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~  
15.8.2.эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах;  
15.8.3.эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, диспетчерийн зохицуулалт хийх, түгээх, хангах, борлуулах үйл ажиллагаа эрхлэх;  
~~15.8.4./Энэ заалтыг 2005 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~  
15.8.5.зуух, даралтат сав, шугам хоолойн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх.  
*/Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн, энэ хэсэгт 2003 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан, энэ хэсгийг 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*  
15.9.Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:  
15.9.1.гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч авах, хөдөлмөр эрхлүүлэх талаар иргэдэд зуучлах үйлчилгээ эрхлэх.  
15.10.Үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр:  
~~15.10.1./Энэ заалтыг 2011 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~  
15.10.2.үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэл эрхлэх;  
~~15.10.3./Энэ заалтыг 2008 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~  
15.10.4.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, экспортлох,



худалдах үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах;  
*/Энэ заалтад 2004 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*  
*/Энэ заалтад 2006 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*  
*/Энэ заалтад 2008 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*  
*/Энэ заалтад 2013 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*  
15.10.5.ашигт малтмалын хайгуул хийх;  
15.10.6.ашигт малтмал ашиглах;  
~~15.10.7./Энэ заалтыг 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~  
~~15.10.8./Энэ заалтыг 2003 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар нэмсэн/~~  
*/Энэ заалтыг 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*  
~~15.10.9./Энэ заалтыг 2003 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~  
~~15.10.10./Энэ заалтыг 2003 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~  
15.10.11.газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах;  
~~*/Энэ заалтыг 2014 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар хассан/*~~  
15.10.12.согтууруулах ундаа импортлох;  
*/Энэ заалтыг 2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар нэмсэн/*  
15.10.13.газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх;  
*/Энэ заалтыг 2005 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмсэн, энэ заалтад 2013 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*  
15.10.14.тамхи импортлох;  
*/Энэ заалтыг 2005 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/*  
15.10.15.төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх;  
*/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн/*  
15.10.16.үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх;  
*/Энэ заалтыг 2009 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*  
15.10.17.бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх;  
*/Энэ заалтыг 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн/*  
15.10.18.газрын тос хайх;  
*/Энэ заалтыг 2014 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/*  
15.10.19.уламжлалт бус газрын тос хайх;  
*/Энэ заалтыг 2014 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/*  
15.10.20.газрын тос ашиглах;  
*/Энэ заалтыг 2014 оны 07 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмсэн/*  
15.10.21.уламжлалт бус газрын тос ашиглах;  
*/Энэ заалтыг 2014 оны 07 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмсэн/*  
15.10.22.үүсмэл орд ашиглах.  
*/Энэ заалтыг 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн/*  
15.11.Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр:  
15.11.1.тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх;  
15.11.2.сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архинаас бусад согтууруулах

ундаа үйлдвэрлэх;

15.11.3.таримал ургамлын үр үйлдвэрлэх;

15.11.4.малын эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох;

~~15.11.5./Энэ заалтыг 2011 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

15.11.6.ургамал хамгаалахад ашиглах бодисыг импортлох, борлуулах;

15.11.7.шинээр малын үүлдэр, омог бий болгох, үр, өндгөн эс, хөврөлийг үйлдвэрлэх, үйлчилгээнд нэвтрүүлэх, бичил биетнийг өсгөвөрлөх, мал, үржүүлгийн бүтээгдэхүүн гадаадад гаргах, гадаадаас сайжруулагч мал, амьтан авах;

~~/Энэ заалтыг 2017 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./~~

~~15.11.8./Энэ заалтыг 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~15.11.9./Энэ заалтыг 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

15.12.Эрүүл мэндийн чиглэлээр:

~~15.12.1./Энэ заалтыг 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

15.12.2.хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, протез үйлдвэрлэх, худалдах, импортлох;

~~/Энэ заалтад 2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/~~

15.12.3.эмнэлгийн тусламж үзүүлэх бүх төрлийн үйлчилгээ эрхлэх;

15.12.4.мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бодис, тэдгээрийн угтвар бодис болон эмийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх, импортлох, экспортлох;

~~/Энэ заалтад 2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хууль, 2011 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар тус тус нэмэлт оруулсан/~~

~~15.12.5./Энэ заалтыг 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

15.12.6.өвчин үүсгэгч нян, түүний хорыг өсгөвөрлөх, үржүүлэх, хадгалах, нөөцлөх, тээвэрлэх, худалдах, улсын хилээр нэвтрүүлэх;

~~15.12.7./Энэ заалтыг 2002 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

15.12.8.ахуйн шавьж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх;

~~/Энэ заалтыг 2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/~~

15.12.9.биологийн идэвхт үйлчилгээтэй бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх үйлчилгээ эрхлэх;

~~/Энэ заалтыг 2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/~~

~~15.12.10./Энэ заалтыг 2006 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/~~

~~/Энэ заалтыг 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

15.12.11.улсын хэмжээний болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагаа явуулах.

~~/Энэ заалтыг 2011 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн/~~

15.13.Зохиогчийн эрх, патентийн чиглэлээр:

15.13.1.оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах.

~~/Энэ заалтад 2010 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/~~

~~15.13.2./Энэ заалтыг 2010 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар~~

*хүчингүй болсонд тооцсон/*

*/Энэ хэсгийг 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн/*

15.14.Барилга, хот байгуулалтын чиглэлээр:

~~15.14.1./Энэ заалтыг 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~15.14.2./Энэ заалтыг 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

15.14.3.цахилгаан шат, өргөх краны угсралт, засвар үйлчилгээ эрхлэх;

~~15.14.4./Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

15.14.5.нийтийн аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;

15.14.6.барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил эрхлэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх;

*/Энэ заалтад 2008 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

15.14.7.геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх.

~~15.14.8./Энэ заалтыг 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

*/Энэ хэсгийг 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн/*

15.15.Зам, тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр:

15.15.1.төмөр замын суурь бүтэц барих, ашиглах;

*/Энэ заалтыг 2007 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

15.15.2.иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэх;

15.15.3.төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх;

*/Энэ заалтыг 2007 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

15.15.4.автозам, замын байгууламжийг барих, засварлах;

15.15.4.авто зам, замын байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх;

*/Энэ заалтыг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/*

15.15.5.автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх;

~~15.15.6./Энэ заалтыг 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~15.15.7./Энэ заалтыг 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~15.15.8./Энэ заалтыг 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

15.15.9.усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх;

~~15.15.10./Энэ заалтыг 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

15.15.11.төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах;

*/Энэ заалтыг 2007 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн/*

15.15.12.тээврийн хэрэгслийн улсын дугаар үйлдвэрлэх.

*/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар нэмсэн/*

- /Энэ хэсгийг 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн/*  
15.16.Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлээр:  
15.16.1.радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах;  
15.16.2.харилцаа холбооны үйлчилгээний сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх;  
15.16.3.контентийн үйлчилгээ эрхлэх;  
*/Энэ заалтыг 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар нэмсэн/*  
15.16.4.тоон гарын үсгийн гэрчилгээ олгох.  
*/Энэ заалтыг 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар нэмсэн/*  
*/Энэ хэсгийг 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн/*  
15.17.Стандарчлал, хэмжил зүйн чиглэлээр:  
15.17.1.хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, суурилуулах, засварлах, худалдах.  
*/Энэ хэсгийг 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн/*  
15.18.Цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн энергийн чиглэлээр:  
15.18.1.цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглалтаас гаргах;  
15.18.2.цөмийн төхөөрөмж ашиглах;  
15.18.3.цөмийн бодис эзэмших, ашиглах;  
15.18.4.цөмийн бодис импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах;  
15.18.5.цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх;  
15.18.6.цацраг идэвхт ашигт малтмал ашиглах;  
15.18.7.цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах, ашиглалтын дараа газар сэргээх;  
15.18.8.цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, худалдах, угсрах, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах, тээвэрлэх, импортлох, экспортлох, хаягдлыг булшлах, аюулгүй болгох болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа.  
*/Энэ хэсгийг 2009 оны 7 дугаар сарын 16-ний өдрийн хуулиар нэмсэн/*  
15.19.Батлан хамгаалах чиглэлээр:  
15.19.1.цэргийн зориулалттай зэвсэглэл, техник, галт хэрэглэлийг экспортлох, импортлох;  
*/Энэ зүйлийг 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/*  
15.20.Гамшгаас хамгаалах чиглэлээр:  
*/Энэ хэсгийг 2017 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар нэмсэн/*  
15.20.1.гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх.  
*/Энэ заалтыг 2017 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар нэмсэн/*

**16 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын байгууллагаас зөвшөөрөл олгох аж ахуйн үйл ажиллагааны төрөл**

*/Энэ зүйлийн гарчигт 2002 оны 7 дугаар сарын 10-ны хуулиар өөрчлөлт оруулсан/*

16.1.Дараахь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд мэргэжлийн хяналтын байгууллага тусгай зөвшөөрөл олгоно:

*/Энэ хэсэгт 2002 оны 7 дугаар сарын 10-ны хуулиар өөрчлөлт оруулсан/*  
~~16.1.1./Энэ хэсгийг 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

16.2.Дараахь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд Аймаг, нийслэлийн Засаг дарга тусгай зөвшөөрөл олгоно:

~~16.2.1./Энэ заалтыг 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

16.2.2.эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагаа явуулах;  
~~16.2.3./Энэ заалтыг 2008 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~  
16.2.4.ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах;  
*/Энэ заалтад 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*  
16.2.5.согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх;  
16.2.6.эмчилгээний гоо заслын үйлчилгээ;  
*/Энэ заалтыг 2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/*  
16.2.7.түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах.  
*/Энэ заалтыг 2014 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/*  
16.3.Дараахь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд сум, дүүргийн Засаг дарга тусгай зөвшөөрөл олгоно:  
16.3.1.агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх, суурин эх үүсвэр ашиглах;  
~~16.3.2./Энэ заалтыг 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~  
~~16.3.3./Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~  
16.3.4.тамхи худалдах.  
*/Энэ заалтыг 2005 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/*  
16.4.Чөлөөт бүсийн захирагч нь энэ хуулийн 16.2.2, 16.2.5, 16.2.6, 16.3.4-т заасан тусгай зөвшөөрлийг олгоно.  
*/Энэ хэсгийг 2015 оны 2 дугаар сарын 12-ний өдрийн хуулиар нэмсэн/*

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **17 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон маргааныг шийдвэрлэх**

17.1.Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдон гарсан маргааныг тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын холбогдох дээд шатны байгууллагад нь тавьж шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

### **18 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

18.1.Энэ хуулийн 6.3, 11.2, 12.1, 12.4, 13.2, 14.2-т заасныг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

18.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

*/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

### **19 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

19.1.Энэ хуулийг 2002 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

*/Энэ хэсгийг 2001 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА      Л.ЭНЭБИШ**